

3. Серик

МУИС-ийн Социологи, Нийгмийн ажлын тэнхмийн багш,
Социологийн магистр

БОЛОВСРОЛЫН ТОГТОЛЦООНЫ ХОЁР ТАЛ БУЮУ “СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ”, “ДЭГ ЖУРАМД ОРУУЛАХ” АСУУДЛЫН ТУХАЙД

Abstract: *In this brief article I want to exchange thoughts about a phenomenon that we do not notice often. A phenomenon veiled behind one noble act that we, Mongolians, accept as one of the most valuable of all human actions for a person, the teaching or educating. I argue that educational structure or the school is similar to Goffman's total institution, and process of learning overlaps with a process of disciplining, as Foucault emphasized. Behind learning, there lie enormous power relations, which in reality too often make us unable to distinguish learning from disciplining. However, these relations in turn produce an order, conditioned with symbolic and non-symbolic power, which regulates subject's conduct and reproduces itself through that very conducts of the subject. I try to show this on the example of a school.*

Key words: *human actions, teaching, educating, symbolic, non-symbolic, school.*

Канад гаралтай Америкийн социологич Эрвин Гоффман (Erving Goffman 1922-1982) символик интеракционизмийн онолыг жинхэнэ утгаар нь хөгжүүлсэн эрдэмтэдийн нэг юм. Түүний бичсэн *The Presentation of Self in Everyday Life (1956)*, *Asylums (1961)*, *Stigma: Notes on Management of Spoiled Identity (1963)* гэх зэрэг томоохон бүтээлүүд нь өнөөдөр ч ач холбогдлоо алдаагүй бөгөөд социологичдын түгээмэл иш татдаг цөөхөн бүтээлүүдийн тоонд багтдаг. Ялангуяа Э.Гоффманы 1955-1956 онд Вашингтонд Ст.Элизабетийн сэтгэцийн эмнэлэгт хийсэн судалгааны дүнг тусгасан *Asylums: Essays on the Social Situation of Mental Patients and Other Inmates* зохиол нь тун сонирхолтой.

Энэ бүтээл нь эмнэлэгт сэтгэцийн өвчтөнүүд хүн болохын хувьд хэрхэн амьдардаг, эмнэлгийн ажилтнуудын өвчтөнүүдтэй харилцах харьцаа, өвчтөнүүдийн нийгмийн ертөнцийг таньж мэдэхэд чиглэсэн үнэ цэнэтэй судалгаа болсон бөгөөд тухайн үедээ багагүй шуугиан тарьж байсан бүтээлийн нэг ажээ. Тэрээр энэхүү судалгаагаараа эмч нарын өвчтөнүүдээ *эмчилж* байна гэсэн нь тэднийг байгууллагын дотоод дүрэмд захируулан “өвчтөн” гэсэн *дүр зүүлэх* үзэгдэлтэй давхцадаг гэж дүгнэсэн байна. Энд Гоффман *total institution* буюу *бүхэл институци* гэсэн ойголтыг дэвшүүлж, сэтгэцийн эмнэлэг бол бүхэл институцийн тодорхой нэг жишээ мөн гэсэн дүгнэлт хийжээ.

Бүхэл институци гэдгийг хүний амьдралын бараг бүхий л хэсгийг тал бүрээс нь захирч зохицуулсан шинжтэй байгууллага (шорон, хорих лагерь, сэтгэцийн эмнэлэг, цэргийн анги гэх мэт) гэж ойлгож болно. Э.Гоффман (1961a) бүхэл интитуцийн үндсэн дөрвөн шинжийг тодорхойлж тайлбарласан байдаг. Энэ бол: 1) өдөр дутмын амьдрал нэг газар, нэг захиргааны хяналтан дор өрнөнө; 2) бүх л үйл ажиллагаа нэг ижил нөхцөлд байгаа хоорондоо адилхан бүлэг этгээдүүдийн дунд явагдана; 3) үйл ажиллагаа хатуу хуваарийн дагуу журамлагдсан, албан ёсны этгээдүүдийн хяналтан дор явагдана; 4) эдгээр хуваарилагдсан үйл ажиллагаа нь ямагт тухайн институцийн зорилго, зорилтыг биелүүлэхэд чиглэгдсэн байдаг (х. б) зэрэг юм.

Энэ бол бүхэл институцийн хамгийн гол шинжүүд юм. Нийгэмд иймэрхүү институци олон байдаг. Харин тэдгээрийг төлөөлж чадахуйц байгууллагын нэг бол *сургууль* (дунд сургууль) байж болох юм. Учир нь энд *сурах* (learning) гэсэн үзэгдэл *дэг журманд оруулах* (disciplining) гэсэн үзэгдэлтэй давхцан илэрч байдаг онцлогтой.

Дунд сургууль бол хүүхдийн нийгэмших үйл явцад хамгийн их нөлөө үзүүлдэг орчин боловч энэ нь нэгэн зэрэг дэг журмын орчин юм. Ангид ар араасаа цуварсан, эгнээ болгон зохион байгуулагдсан сурагчдын ширээнүүд бол дэг журмын хамгийн анхны илрэл мөн. Ширээний ард сурагчдыг нэр заан суулгаж, зай болгоныг өөрийн тодорхой эзэмшигчтэй

болгож, хамаагүй өөрчлөгдөхгүй болгох нь дараа дараагийн дэг журамд оруулах үзэгдлүүдийн нэг мөн. “Орон зайд элементүүд буюу хүмүүсийг эхлээд байршуулах нь дэг журмын эхний үзэгдэл юм” (Фуко:141). Энэ нь хожим хэн байна, хэн байхгүй вэ гэдгийг тодорхойлж байх үзүүлэлт мөн. Анги гэдэг нь өөрөө зөвшөөрөл авч орж гардаг *хаагдмал* орчин юм.

Дэг журамд оруулах үзэгдэл нь аль эрт, бүр сургуульд орохоос өмнө цэцэрлэгийн болон сургуулийн бэлтгэлийн үед эхэлдэг. Энэ үед хүүхдүүд янз бүрийн өнгө, *дүрс* бүхий үсэг, тоо бичих дүрсэн тоглоомуудтай тоглодог. Энэ нь угтаа тоо болон үсэг бичиж сурах анхны алхамууд юм. Үсэг болон тоог дүрсээр *яаж* бичихийг заах нь *яаж хийх, яаж байх* вэ гэсэн дэг журмын хэм хэмжээнд орж эхэлж буй шинж мөн. *Яаж, хэрхэн* гэдэг бол *сурах* болон *дэг журамтай* байх үзэгдлийн үндэс болно.

Францын сэтгэгч Мишель Фуко (Michel Foucault 1926-1984) *Discipline and Punish: The Birth of the Prison* (1975) хэмээх бүтээлдээ дэг журмыг тодорхой авч үзээд “дэг журам шууд *биен* (body) дээр тусч илрэн биеийг хянах, зохицуулах, ашиглахад чиглэсэн байдаг” гэжээ. М. Фуко ([1975] 1995) “биеийн үйл ажиллагааг нэг бүрчлэн хянах боломж олгон, түүнээс гарах хүчийг захируулах, хэрэглээ [(utility)] болгох боломжийг олгож буй аргуудыг дэг журам гэж ойлгож болно” (х.135) гэж тодорхойлсон байдаг.

Сурагчдыг тодорхой ялгаралд оруулахгүйн тулд дүрэмт хувцастай болгох нь үүний хамгийн тодорхой жишээ мөн. Түүнээс гадна ширээний цаана нуруугаа эгц шулуун, зүүн гар дээрээ баруун гараа тавин, хөлөө ширээний хөндлөвчинд тавин суу, гутлаа тосол, үсээ зөв самна, хумсаа ав гэх зэргээр сурагчдад заах нь үүний бас илрэл юм. Мөн хаалга тогшиж ор, зөвшөөрөл авч гар, ширээний ард дэвтэрээ зүүн тийш 45 градус хазайлган тавь, үзгээ зөв барьж биеэ ширээнд наалгүй *зөв* суу, цэвэрхэн бич, цэнхэр үзгээр бич гэх зэрэг нь шууд дэг журамд оруулж буй үзэгдэл мөн (цэцэрлэгийн бэлтгэлийн үед хүүхдүүдэд халбага, сэрээ яаж барих, хэрхэн идэх, мөн хэрхэн алхахыг заадаг).

Түүнчлэн хичээлийг хатуу тогтоосон цагийн хуваарийн дагуу явуулах, тогтсон ёсоор мэндлэх, хичээл эхлэх болон дуусахыг заасан хонхны дуу хүртэл тодорхой үйл ажиллагаа явуулах буюу зогсоохыг заасан дохио юм. Гэрийн даалгавар хэмээх *давтан үйлдэх* үйлдэл нь ч тасралтгүй дэг журамд оруулж буй үзэгдэл мөн. Харин энэхүү гэрийн даалгаврууд нь тодорхой хугацааны дотор биелэгдэх шинжтэй байдаг. Ийм хугацааны хуваарилалтууд нь нэг ёсондоо, М.Фукогийн хэлснээр *дэг журмын цаг хугацаа* (disciplinary time) юм ([1975] 1995:150).

Шийтгэл/урамууллын тогтолцоо болсон ангид мөн цаг хугацааг чанартай ашиглахыг заадаг. Тухайлбал, сургуульд сурагчдад залхуурлын эсрэг ухуулгыг идэвхтэй явуулдаг. Ганц энэ биш, хүүхдүүдийг дүгнэж цэгнэх, үнэлгээ өгөхийг хүртэл дэг журамд оруулж буй үзэгдэл гэж ойлгож болно.

Англи хэлэнд *шавь* (disciple), *сахилга бат/дэг журам* (discipline), *салбар шинжлэх ухаан* (discipline) гэдэг үгнүүд бүгд нэг язгууртай нь санамсаргүй зүйл биш. Мөн монгол хэлэнд “эрдэмтэй хүн номхон, их мөрөн дөлгөөн”, “эрхийг сурахаар, бэрхийг сур”, “номыг нь сурдаггүй юм аа гэхэд номхоныг нь сур” гэх мэт үгс байдаг.

М.Фуко ([1975] 1995) “дэг журам биеэс ялгарах хүчийг ихэсгэж (эдийн засгийн хэрэглээ талаас нь) мөн багасгадаг (улс төрийн *дуулгаврын* хувьд)” (х. 138) хийгээд мөн “хэрэв эдийн засгийн мөлжлөг нь хүч болон хөдөлмөрийн бүтээгдэхүүнийг бие биенээс нь салгадаг бол дэг журмын албадлага нь биед өсөн нэмэгдэх чадвар болон өсөн нэмэгдэх ноёрхол хоёрын хооронд бат бөх холбоог тогтоож өгдөг” (Фуко:138) гэж тодорхойлжээ. Энд, Фукогийн хэлснээр, багшийн *чиглүүлэх арга барил* (technique of command) болон сурагчийн *дуулгавартай зан чанарын* (morality of obedience) хооронд холбоо тогтож байгаа хэрэг ([1975] 1995:166) бөгөөд *сайн сурагч, сайн хүүхэд* гэсэн ойлголт үүгээр тодорхойлогдох нь ховор бишээ.

Э.Гоффман бүхэл институцийг тодорхойлохоос гадна бүхэл институцид, тухайлбал, Гоффманы сэтгэцийн эмнэлэгт ажилтнууд болон өвчтөнүүдийн хооронд асар их *нийгмийн зай* (social distance) ялгаран гарч байдаг гэж үзсэн байна (Смит 2006:71). Энэ бол бүхэл институциудад байдаг үндсэн шинж бөгөөд энэ хоёр давхаргын хооронд бараг шилжих хөдөлгөөн байдаггүй. Сургуульд ч мөн адил багш болон сурагчдын хооронд ийм асар их нийгмийн зай байдаг ба багш нарын сурагчид руу чиглэсэн харьцаа нь ямагт *ноёлсон* (dominating) шинжтэй байдаг. Тухайлбал, нийслэлийн ...-р дунд сургуулийн сурагч орос хэлний олимпиадаас чөлөөлж өгөх хүсэлт сургуулийн захиргаанд гаргажээ. Гэтэл энэ нь тус сургууль байгуулагдсанаас хойшхи хорин жилийн түүхэнд сурагчаас гаргасан анхны хүсэлт байв. Энэ нь хүүхдүүдийн ухамсарт дуулгавартай байх зан чанар хэрхэн гүн шингэснийг харуулж буй жишээ юм. Ийм байдлаар төлөвшсөн зан чанар нь Монгол Улсын сургуулиудад

байдаг зохиомол хүнд суртлын оршин тогтнох үндэс бөгөөд эргээд багш болон бусад захиргааны ажилтнуудад асар их символик болон символик бус эрх мэдлийг олгож байдаг (сурагчдыг зодохоос авахуулаад янз бүрийн үзвэр үйлчилгээний тасалбарыг албадан тулгах г.м). Манай оронд сурагчдаас сургуулийн захиргаанд гаргасан өргөдөл, гомдол, хүсэлт хэрхэн шийдэгдэж, хэрэгждэг нь сонин байж болох юм.

Дэг журамд оруулах үзэгдэл нь сургуулиас гадна бас шинээр ажилд орж буй хүний хувьд ч бас түгээмэл ажиглагддаг байна. Тухайлбал, нэгэн иргэн төрийн байгууллагад ажилд ороод хэдхэн өдөр болж байтал хуучин ажилтны нэг нь хонуулж ажил хийлгэхийг шаарджээ. Энэ нь бодвол ажил хийлгэж “сургаж” байгаа нь бололтой юм. Хуучин ажилчид өөрсдийгөө албан бус статусын хувьд ямар нэгэн байдлаар шинэ ажилчнаас “дээгүүр” гэж боддог, эсвэл энэ хүн “шинэ” гэсэн утгаар хандах нь дэг журамд оруулах шалтгаан болдог байна мөн, “...шинэ ажилчдын толгойг нь илээд хэрэггүй!, ...барын зулзагыг бага дээр нь дараад ав!” гэх зэрэг бодит шалтгаангүй хүнд суртал түгээмэл байдгийг хэлэх хэрэгтэй.

Сурах (learning) болон дэг журманд оруулах (disciplining) үзэгдэл ямагт хамт илэрдэг нь анхаарал татахуйц сонин зүйл бөгөөд аль нь давамгайлах нь мэдэгдэхүй тохиолдол түгээмэл юм. Жишээ татъя. Нэг оюутан бие даалтын дагуу эссе бичээд багшдаа хураалгажээ. Тэгтэл оюутан “С” авчихаж. Оюутан ийм дүн авсанд ихэд санаа зовон багш дээрээ очиж юун дээр алдсанаа тодруулсан байна. Гэтэл багш нь түүний бичсэн эссе харж байснаа (мөн оюутны материал дээр бичсэн өөрийн тайлбарыг ойлгохгүй байв) “Чиний эссе хамгийн түрүүнд ирсэн болохоор би хатуурхаж байгаад С тавчихаж” (!?) гэж хэлээд дүнгийг нь засаж өгсөн байна. Өөр нэгэн сурагч (оюутан биш) математикийн шалгалт өгчээ. Шалгалтын дараа багш нь түүний бодлогыг нь шалгаад зөв хариу гарсан ч “дөрөв” тавчихаж. Сурагч учрыг нь асуутал багш нь “Бичлэг муухай байна” (!?) гэж математикийн бодлогыг дүгнэжээ.

Хүний нийгэмших үйл явцад асар их нөлөө үзүүлдэг сургууль хүүхдүүдийг бүхэл институцийн загвараар ингэж дэг журманд оруулан хүмүүжүүлдэг бол Монгол Улсын хувьд хүнд суртал болон шийдвэр гаргах үйл явц магадгүй “мөнхийн” асуудал хэвээр үлдэж болох юм. Өөрөөр хэлбэл, Монгол Улсад хүн дуулгавартай байх, хүлцэнгүй байх зан чанараар төлөвшин ийм маягаар нийгэмшдэг гэвэл Монгол Улс дахь аливаа нийгмийн институтуудад бий болдог хүнд суртал хэзээ ч дорвитой түвшинд багасч, өөрчлөлт хэрэгжихгүй гэж ойлгож болно. Хүнийг ингэж “үйлдвэрлэх” нь нэг том арга техник биш. Харин Фукогийн хэлснээр, эдгээр нь янз бүрийн жижиг сажиг техникүүд ба нийлээд нэгэн ерөнхий аргыг бүрдүүлж байдаг байна. Энэ нь шууд гаргасан шийдвэрийн шинжтэй үйлчлэх биш, харин хүний янз бүрийн жижиг сажиг үйлдлийг зохицуулсан шинжээрээ давамгайлдаг байна. Хүнд суртлын хэмжээ нь үйлчлүүлж буй субъектуудын статусаас (хүүхдүүд) хамаарах сургууль нь нийгэмд асар их үүрэгтэй институци мөн бөгөөд нийгмийн бүтэц бүрэлдэхэд асар их нөлөөтэй байдаг.¹⁰⁹

Ашигласан материал

1. Goffman, Erving (1961a). *Asylums: Essays on the Social Situation of Mental Patients and Other Inmates*. New-York: Doubleday, Anchor books
2. Smith, Greg (2006). *Key Sociologists: Erving Goffman*. New-York: Routledge
3. Foucault, Michel (1995). *Discipline and Punish: The Birth of the Prison*. Vintage books

¹⁰⁹ Өгүүллийг бичих явцад судалгаанд оролцож ярилцлага өгсөн хүмүүст талархал илэрхийлье.